

Эх оронч монгол, үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхын зарим асуудал

С.Лхагвасүрэн¹, Ц.Нарангэрэл²

¹Зэвсэгт хүчний дугаар анги

*²Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэн,
Цэргийн түүх судлалын төв*

Key words:

Motherland,
nation, resistance,
resilience, tolerance,
ability.

Abstract: In the article titled Patriotic Mongolia and Some Issues of National Resilience, it is commendable for promoting youths who are the future of our country, listening to them, supporting them, appreciates their work, creatively searching for solutions, increasing the participation of youth in decision-making, and cultivating a sense of love and pride for their country, are being promoted and promoted at all levels, starting from the head of state. Therefore, We wrote this article to convey our voices and opinions.

Удиртгал

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Засгийн газар хөгжлийн тулгамдсан асуудал, тулгарч байгаа сорилтуудыг илүү хурдан, үр дүнтэй шийдвэрлэх, бүрэн эрхийнхээ хугацаанд бүтээлчээр, тогтвортой хамтран ажиллах зорилгоор “Хурдтай хөгжлийн төлөөх зориг” Засгийн газрын гэрээг байгуулж 4 дүгээр бүлгийн 4 дүгээр зүйлд “Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх ба амар тайван нийгэм”¹ гэсэн цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна. Иймд эх оронч байх, төр түмнийхээ төлөө байх, өөрсдийн орны ирээдүй болсон залуусыг сонсдог, дэмждэг, тэдний үйл хэргийг бодитоор сайшаан үнэлдэг, гарц шийдлүүдийг бүтээлчээр хайн илрүүлж, шийдвэр гаргах түвшинд залуусын оролцоог улам бүр нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Төр нь нийгмийн гол цөм болсон залуу үедээ анхаарлаа хандуулж эх оронч Монголыг бүтээж чадваас үндэсний аюулгүй байдал бүрэн хангах боломжтойг олж харан стратегийн түвшинд энэхүү асуудлыг хөндөж буй нь Монголын залуу үеийг дижиталчлал, даяаршлын шуурганд өртөж буй мэдээллийн дайнаас авран хамгаалах, зөв тийш нь чиглүүлэх нь олзуурхууштай арга хэмжээ хэмээн ойлгогдож байна.

“Монгол Улсын иргэн бүрийн үндэсний үнэт зүйлээрээ бахархагч, тэдгээрийг хайрлан хамгаалагч, тээн хөгжүүлэгч байх эх оронч үндэсний

¹ Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт. Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр;

үзэл, улс, үндэснийхээ ирээдүйн сайн сайхны төлөө хувь нэмрээ оруулахыг эрмэлзсэн идэвхтэй үйл ажиллагаа нь үндэсний аюулгүй байдлыг хангах бодлого, үйл ажиллагааны эх үндэс болно”² хэмээн тодорхойлсон нь Эх оронч үндэсний үзэл үндэсний аюулгүй байдлын үндэс гэдгийг харуулж байна. Тэгвэл Монгол түмэн бидийг нэг чигт харах, нэг зүгт хөдлөх хүч болох тэр зүйл нь эх орон, түүнийг хайрлах, түүгээр бахархах үзэл байх болно.

Өнөөдөр “Эх оронч үзэл”, “Эх оронч Монгол хүн” гэдэг нь яг хэнийг хэлэх, түүнийг албан байдлаар тодорхойлсон тодорхойлолт байхгүй байна. Хүн бүр өөр өөрийн үзлээр тодорхойлж байгаа мэт үзэж эндүү, ташаа ойлгож байгаа нь тусгаар тогтносон улсын хувьд сул тал хэмээн өөрийн зүгээс харж байна. Нөгөө талаас албан ёсны хууль эрх зүйн баримт бичигт тодорхойлон тусгаагүй нь нэгдсэн ойлголтод хүргэхгүй хамгийн том сул тал болоод байна.

Эрдэмтэн, судлаачдын тодорхойлолтоос иш татан дүгнэж үзвээс хэт их үндсэрхэг үзлийн үүднээс бус өөрсдийгөө таних, хөгжүүлэх, дангааршил хийгээд даяаршихуйд нийцэхүйц чадвартай, эх орныхоо үнэ цэнэ, өв уламжлал, үүх түүх, ёс заншлаараа ондоошдог, түүнийхээ төлөө зүтгэдэг, хөдөлмөрлөдөг, зүрх нь цохилж, цус нь урсдаг юугаар ч сольж үл барах ганхашгүй, бат тогтвортой үзэл, төлөвшлийг хэлж болно.

Эх оронч Монгол гэдэг бол дээрх зарчимд тулгуурласан, эх орныхоо хөрсөнд хөгжлийн үр, хүн чанарын үндсийг тарьж ургуулахад боловсорсон, аливааг шүүн тунгаах чадвартай, ардчиллын үнэ цэнэ, өөрийн улсын ондоошлыг ялган таньж, бусдын соёлд хүндэтгэлтэй ханддаг, үзэл баримтлалдаа үнэнч, оюунлаг Монгол хүмүүсийн нэгдлийг хэлж болохоор байна.

Мөн үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх гэдгийг тодорхойлох нь зүйтэй. Иймд үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх гэдэг нь үндэс угсаа, уг гарвал нэгтэй, үндэстний урт удаан хугацаанд тэсвэрлэх чадварт тулгуурласан сөрөх үйлдлийг хэлнэ. Тухайлбал: Хэл соёл нэгт тусгаар тогтносон ард түмнийг буюу 2024 оны байдлаар 30 угсаатны бүлгээс бүрдсэн Монгол үндэстнийг хэлнэ³ хэмээн үзсэнтэй санал нэг байна.

Дээр дурдсан үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх гэдгийг үг зүйн үүднээс авч үзвэл дараах байдлаар тодорхойлогдож байна. Үүнд: сөрөх үгийн утга нь 1. Ус, салхи зэргийн урсгалын өөдөөс зүсэн явах; урсгал сөрөх; салхи сөрөх;

² Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолын хавсралт. “Монгол Улсын Үндэсний Аюулгүй байдлын үзэл баримтлал”. 1.2.1 дүгээр зүйл;

³ Г.Цэрэнханд, Н.Маралмаа нар. “Монголын угсаатны зүйн судалгаа ба орчин үе”. УБ., 2020. т 472;

2. Ширхгийн дагуу биш, түүний эсрэг болох; 3. Зөрчих, эсэргүүцэхийг⁴, тэсвэрлэх үгийн утга нь хүлцэж чадах, даах, давах; тэсвэрлэн давах; тэсвэрлэн өнгөрүүлэх; зовлон тэсвэрлэхийг⁵, чадавх үгийн утгыг чадал үгийн утгатай хамаатуулан 1. Тамир тэнхээ, бяр хүч; чадал тэнхээ, бяр чадал, хүч чадал хорш; чадал заах (а. Ажил юмыг хэтийдсэн хүчээр хийх; б. Эрдэм чадвар сайтай байх; ёстой чадал зааж эрдэмтэн болсон хүн ...), чадал суух (эрдэм чадал улам нэмэгдэх, чадал суух); 2. Эрдэм мэдлэг, чадвар, мэдэц; ид чадал, мэдэл чадал, эрдэм чадал⁶ гэсэн үг зүйн утгыг илэрхийлж байна.

Даяарчлал, дижиталчлалын эрин буюу мэдээллийн дайнд бид үндэсний аюулгүй байдлаа хамгаалан эх орончоор, яаж сөрөх, юуг тэсвэрлэх гэдгээ мэдэрч өөрсдийгөө хөгжүүлж, ирээдүйгээ бэлдэх шаардлага өнөөдөр тулгамдаад байна.

Үндсэн хэсэг

Эх оронч үзэлтэй, сөрөн тэсвэрлэх чадавхтай буюу Монгол ахуйгаараа, сэтгэхүйгээрээ, ондоошлоороо, түүхээрээ, соёлоороо, уламжлалаараа үнэт зүйлсээ таньж, хадгалж, өвлүүлж байх нь иргэн бүрийн үүрэг хэмээн үзэж байна. Уг чадавхыг нийтээр эзэмшиж зөв дадал, зөв үйлдэл болгож чадсанаар сая үндэсний аюулгүй байдал дайн, аюул, занал, эрсдэлд хэлбэрэлтгүй байх суурь тавигдах ёстой.

Харин өнөөдөр нэгдүгээрт, гадаад улс орон руу жуулчлалаар, ажлаар, суралцах шалтгаанаар, байнгын оршин суугчаар шилжих иргэдийн хөдөлгөөн эрс нэмэгдэж, хүн ам удмын сангийн аюулгүй байдалд сөрөг нөлөөлөхүйц үйл явдал өрнөж байгаа, хоёрдугаарт, хүүхэд багачууд, залуусын өдөр тутамд хийгддэг кино контент, олон нийтийн сувгаар гарах мэдээлэл, зар сурталчилгаа нь дийлэнх нь харийн хэл дээр, бусад орны улсын сэтгэлгээ, соёл, амьдралын хэв маяг, түүх, ёс заншлаар хийгдсэн мэдээ мэдээллийн урсгал ямар нэгэн шүүлтүүргүйгээр хүрч байгаа нь хувь хүн, бие хүн болон төлөвших процесст шууд утгаараа сөргөөр нөлөөлж байна, гуравдугаарт, тогтолцооны гажуудал, амьдралын хэвшлийн буруу хандлага төлөвшлөөс үүдэлтэй гэр бүлийн тогтворгүй, сарнисан саармаг байдал нь өсөхөөс төлөвших хүртэлх үеийнхнийг өөрийн гэсэн үзэл баримтлал, суурь төлөвшилгүй, үнэт зүйлгүй, бат итгэлгүй болгож байна. Үүний хор уршиг даяаршил нэрийн дор хүчирхэг гүрнүүдийн явуулж буй уусган нэгтгэх мэдээллийн дайнд, залуусыг урсгалаараа хөвж яваад нэгдэх аюулд хүргэж байгаа нь сүүлийн жилүүдэд улам их ажиглагдах боллоо.

Миний бодлоор даяаршил нэрийн дор хүчирхэг гүрнүүдийн явуулж буй уусган нэгтгэх мэдээллийн дайныг сөрж тэсвэрлэх үүднээс улс тодорхой

⁴ Я.Цэвэл. “Монгол хэлний товч тайлбар толь”. УБ., 2021. т 704;

⁵ Мөн тэнд. т 842;

⁶ Мөн тэнд. т 1173;

шийдвэр гаргасан хэмээн үзэж болно. Тухайлбал: Засгийн газрын 2019 оны 200 дугаар тогтоолын хавсралт⁷, “Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр, Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт⁸ Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол улсын Батлан хамгаалахын яамнаас 2025 онд зарласан “Их сэргэлтийн жил”-ийн бодлого, 2024 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн дугаар 166, “Монголын түүх судлалыг дэмжих тухай”⁹ Монгол улсын ерөнхийлөгчийн зарлиг зэрэг нь сөрөн тэсвэрлэх, чадавхыг нэмэгдүүлэх, залуусын сэтгэл зүйн болон оюуны дархлааг бат бөх болгоход дэмжлэг үзүүлэх чухал ач холбогдолтой хөтөлбөрүүд юм.

Нөгөөтээгүүр бодлогын түвшинд байгалийн гамшиг, гоц халдварт өвчин, тахал, нийгэм эдийн засгийн хямрал, мэдээллийн болон кибер халдлага, дайн бүхий байдал гээд аливаа эрсдэл аюул нүүрлэсэн үед бүх нийтээрээ бэлэн байх, дасан зохицох, даван туулах, түргэн сэргэх чадавхыг нэмэгдүүлэх, бий болгох үүднээс сөрж тэсэх, сэргэж ухаарах, сэргэж нэгдэх цаг болсныг хэлэлцэж, хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлж байгаа нь Монгол Улсын иргэний хүний хувьд талархууштайгаар хүлээн авч байна.

Түүхэн үүднээс авч үзвэл улс төр, стратегийн ач холбогдол бүхий газар нутагтай манай улсын хувьд өнөөгийн нийгэмд тулгамдаж буй аюул, занал улс орны хөгжлийн аль ч үед байсаар байжээ. Тухайлбал: НТӨ III зуун буюу Хүннү гүрний үед Хань улсын зүгээс нүүдэлчдийг булаан эзлэх, үндэсний үнэт зүйлсийг алдагдуулах зорилгоор хагалган бутаргах, бэлэг сэлт өгөх замаар өөрийн зан заншилд автуулан талдаа оруулах бодлого баримталж байв. Хан улс Хүннүд бэлэг сэлт нэрийн дор татвар өгч байхдаа Хүннүг эдийн засгийн аргаар сулруулан доройтуулж, эв нэгдлийг нь дотроос нь задлан бутаргах арга хэрэглэж¹⁰ байсан. Тэдний энэ аргын нэрийг “Цзими” буюу “Бэлгэдэн хазаарлах” гэх ба аргаа хэрэгжүүлэхдээ “Таван урхи” гэдгийг боловсруулж гаргажээ. Таван урхи гэдэгт:

1. Нүүдэлчдийн нүдийг урвуулахын тулд тэдэнд үнэт бөс бараа, тэрэг өгөх;
2. Амыг таглахын тулд амттай сайхан хоол хүнс өгөх;
3. Сонорыг урвуулахын тулд сайхан хөгжмөөр татах;
4. Ходоодыг урвуулахын тулд тэдэнд гоёмсог сайхан байшин сууц, үр тариа хадгалах агуулах барьж өгч, боол шивэгчинг бэлэглэх;

⁷ Монгол Улсын Засгийн Газрын Тогтоол. 2019 оны 5 дугаар сарын 22-ны өдөр. Дугаар 200., УБ.хот. “Үндэсний хөтөлбөр батлах тухай”;

⁸ Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр;

⁹ Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг. 2024 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр. Дугаар 166., УБ.хот. “Монголын түүх судлалыг дэмжих тухай”;

¹⁰ Т.Эрдэнэхишиг. “Хүннү, Хань улсын цэрэг, улс төрийн харилцаа”. УБ., 2009. т 121;

5. Хятадад дагаж ирвэл, тэдэнд онцгой анхаарал тавьж, үнэт бэлэг сэлт өгөх зэрэг аргууд багтдаг байв¹¹.

Эдгээр нь хүнийг таван мэдрэхүйгээр нь дамжуулан урвуулан татах арга юм. Хүннүгийн зарим ноёд эл урхинд орж, Хятадын бараа сэлтэд дурлаж байсан талаар баримт байдаг. Хэдий энэ мэтийн хагалган бутаргах арга хэмжээнд хэсэг бүлэг язгууртан, ноёдууд автаж байсан боловч удирдагчийн удирдан чиглүүлэх, үзэл сурталдаа үнэнч байх, тусгаар тогтнол, эх орноо хамгаалан үлдэх бат тогтвортой болгох дархлаа, үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг нь тодорхойлж байжээ. Үүнээс дүгнэхэд, удирдагчийн санаа бодол бат тогтвортой, эх орон, тусгаар тогтнолынхоо төлөө гэсэн дархлаатай байх аваас хялбар эзлэгдэхгүй нь баттай. Өнөөдрийн Засгийн газар, Монгол Улсын Их Хурал, Зэвсэгт хүчний ерөнхий командлагч буюу Монгол Улсын Ерөнхийлөгч нь ард түмний оюун санаа, мэргэн сонголтоор гарч ирж буй тул удирдагчид эргэлзэх эрх бидэнд үгүй гэсэн ойлголтыг төрүүлж байна. Гэвч өнөөдөр ард түмний сонголт мэргэн эсэх нь эргэлзээтэй? Харин эргэлзэхгүй байхын тулд сонгож буй удирдагчдын үг, үйлдэл, үзэл бодлыг иргэн бүр хянах учиртай.

Түүхийг хойшлуулан нэгэн баримт дурдвал: Манжийн эрхшээлд 200 гаруй жил болсон Монголчууд XX зууны эхээр Үндэснийхээ эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө эрслэн босож, тухайн үеийн тэргүүн язгууртнууд манлайлан хувьсгал хийж 1911 оны 12 дугаар сарын 29-нд Манж Чин гүрнээс салж тусгаар улс болсон гэдгээ тунхаглан зарласан байдаг¹². Энэхүү тэмцэлд олон хүчин зүйл нөлөөлсний нэг нь ард олны сэтгэл зүрхэнд их эзэн Чингис хааны үр сад монгол үндэстэн бид эх нутаг, газар шороон дээрээ эрх чөлөөтэй, үндэстнийхээ төр засаг, хууль дүрэмтэй тусгаар байх ёстой гэсэн үзэл санаа нэвт шингэсэн байсан учраас тэмцлээ өрнүүлж ялалтад хүрснийг түүх гэрчилжээ.

Үндэсний тусгаар тогтнолыг сэргээх, үндэсний эрх чөлөөний удирдлагыг нэг гарт зангидах, мөн гаднаас тусламж үзүүлэх хүчнийг сонгож холбоо тогтоох зэрэг зорилтыг дэвшүүлж тавьсан байдаг.

Богд Живзундамба хутагт оюун санааны удирдагч нь байж “одоо цаг нь болсон” хэмээн лүндэн буулгаж ард иргэдээ уриалан дуудсан бол Чин ван Ханддорж, сайн ноён Намнансүрэн, Түшээт хан Дашням, Сэцэн хан Наваанцэрэн тэргүүтэй ноёд манлайлан тэмцлээ ялалтад хүргэсэн түүхтэй.

Монгол орныг харийн түрэмгийлэгчдээс чөлөөлж, тусгаар тогтнолоо сэргээн мандуулах хувьсгал хийж 1921 онд Ардын хувьсгал ялсан түүхэн үе ч иргэдийн оюун санаа, зохион байгуулалт дайсан этгээдийг эсэргүүцэх, эрх

¹¹ Мөн тэнд. т 122;

¹² Улсын Их Хурлын 2011 оны намрын ээлжит чуулганы 12 дугаар сарын 28-ны өдөр (нүрэв гариг)-ийн хүндэтгэлийн чуулганы хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл., т 4;

чөлөөгөө олж авах ганцхан зорилго тэмүүлэлтэй байсныг түүх гэрчилнэ.

Түүхийн бүхий л үеүдэд дайн тулааны стратегид эсрэг талын зориг эрмэлзэл, хүсэл санаархлыг няцаах-унагаах, өөрсдийн итгэл үнэмшил, хүсэл зоригийг бадраах, бэхжүүлэх асуудал ялалтад хүрэх түлхүүр байсныг цэргийн түүх судлаачдын суурь судалгааны бүтээлүүдээс харж болно. Тухайлбал: “Монгол цэргийн түүхийн товчоон”,

Монголын төр, засаг үндэснийхээ эрх ашиг, тусгаар тогтнолоо хамгаалахын тулд ЗХУ-тай “Харилцан туслалцах гэрээ”¹³ байгуулж ард иргэдээ эх орноо хамгаалах үйл хэрэгт уриалан дуудаж, үзэл суртлын өргөн хүрээтэй ажлуудыг хийж байлдааны талбарт байлдаж буй дарга, цэргүүдийн сэтгэл санааг зөвхөн тэмцэлд чиглүүлж чаджээ. Өөрөөр хэлбэл, үндэсний эв нэгдэл, оюун санааны нэгдмэл байдал, дархлаа нь үндэсний сөрөн тэмцэх, эсэргүүцэх чадварыг суулгадаг байна.

Тиймээс иргэн бүрийн шийдэх нэн тэргүүний ажил бол оюун санаа, эв нэгдлийн дархлаагаа бат тогтвортой байлгах үйл хэрэг билээ. Гэтэл сүүлийн жилүүдэд эх оронч үзэл, үйлдэлтэй иргэдийн тоо цөөрөх хандлагатай байгаа нь ажиглагдаж байна. Тухайлбал: 2020 оны байдлаар гадаадад байнгын оршин суугчдын тоо 3514 байсан бол 2024 оны байдлаар 60852 буюу 1.731,7 хувиар буюу 17,3 дахин өссөн, 9-с дээш сараар зочлох жуулчлагчдын тоо 17,864 байсан бол 2024 оны байдлаар 351,315 буюу 1.966.6 хувиар буюу 19,7 дахин өссөн байгаа нь шилжих хөдөлгөөн нэмэгдэхээс гадна иргэдийн санаа бодол хувьсан өөрчлөгдөж, эх орондоо ажиллаж, ая тухтай амьдрах орчин нөхцөл хангагдахгүй байна гэж үзэж байгаагаас үүдэлтэй. Залуусын санаа бодолд гадаадад гарч сурвал өндөр боловсрол эзэмшин, гадагшаа гарч ажиллавал санхүүгийн хувьд хурдан хараат бус болно, гуравдагч оронд очвол бүх талаар эрх чөлөөтэй байх эрхийг эдэлж чадна гэсэн өрөөсгөл ойлголттой байгаа !!!... Гэвч бүх зүйл бодит байдал дээрээ өөр байгааг тэд очсон хойно оо л мэдэрдэг. Нөгөөтээгүүр Монгол Улсын үндсэн хуульд “Монгол Улсын иргэн дараах үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ¹⁴: “16.2/эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй; 16.3/хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй. ..., 16.4/ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах ..., 16.6/эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах..., 16.16/итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх...,” эрхээ эдэлж чадахгүй байна гэсэн өрөөсгөл үзлээс үүдэлтэй сэтгэлгээний дутмагшил нь аливаа бэрхшээлийг сөрөн тэсвэрлэх чадавхад суралцах, эх оронч үзлээр

¹³ Олон Улс Судлал Vol. 46 | No 115 | 2023 <https://doi.org/10.5564/jis.v46i115.2685>, Академич, доктор Ц.Батбаяр. “Монгол Зөвлөлтийн харилцаа (1925-1928)”. УБ., 2023. т 85;

¹⁴ 1992 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр. Монгол Улсын Үндсэн хуулийн 2 дугаар бүлгийн 16 дугаар зүйл;

хандах, хандлагыг зогсонгшилд оруулж байна гэж үзэх үндэслэлтэй.

Иймд нэг талаас төрийн шийдвэртэй алхам хийх, тогтолцооны гажуудлыг засах, иргэдийн эх орондоо амьдрах, ажиллах үзлийг нэмэгдүүлэх, нөгөө талаар иргэн бүр эх орноо хайрлан хамгаалах үзэл төлөвшлийг өөртөө болон үр хүүхэд, өрөөл бусдад төлөвшүүлэх хандлагатай болох шаардлагатай байна. Иймд залуус нэн түрүүнд амьдралын зөв хэвшил, дадалд өөрсдөө суралцах, үр хүүхдээ суралцуулах, бусдад нөлөөлөх, чадавхтай болох шаардлагатай байна. Иймд бусдаас бус өөрсдөөсөө дутагдлыг олж, засдаг сайжруулдаг, зөв хандлагатай цөөнх биш олонх болох нь нэн чухал юм.

Өнөөдөр мэдээллийн дайнд өртөхгүй, өртсөн ч хохирол багатайгаар даван туулахын тулд өдөр тутамдаа мэдээллийн хэрэгсэл, ухаалаг төхөөрөмж, цахим орчинг зөв зохистой ашиглах хэрэгцээ амьдралаас урган гарч байна. Жишээлбэл: Сургуулийн өмнөх боловсролоос их дээд сургуулийн оюутан залуусыг хамруулсан 1,256,400 иргэнээс судалгаа авсан байдлыг баримт болгоход 6 – 20 насны 1,184,342 хүүхэд, залуучууд мэдээлэл боловсруулж эхлэх цагаасаа л олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, сүлжээ, гар утас, тоног төхөөрөмжөөс шууд хамааралтай байгаа нь нотлогдсон¹⁵. Мөн олон нийтийн сүлжээнд холбогддог мэдээллийн хэрэгслийг ашиглан өдөрт 1-15 цагийн хугацаатай ямар нэгэн шүүлтүүргүй мэдээллийг өсвөр насандаа авч байгаа нь эх оронч үзэл, төлөвшихөд шууд сөргөөр нөлөөлж байна. Уг нөлөөлөл нь Монгол хүн, Монгол иргэн гэдгээ мэдэж, ухаарч эхлэх үедээ сөрөг, баталгаагүй мэдээлэлд өртөх болсон гэж хэлэхэд хилсдэхгүй. Учир нь өсвөр насныхан хөгжингүй орон (АНУ, БНХАУ, ОХУ)-ны захиалгат нэвтрүүлгийг үзэж, бусад орны соёлоор сэтгэсэн, бусад орны үзэл суртлыг агуулсан, бусад орны хэлээр ярьсан, сэтгэсэн, тэдний оюун бодол санаагаар бүтсэн, ёс уламжлалыг нь агуулсан нэвтрүүлэг, богино хэмжээний бичлэг, кино контентуудыг үзэж өсөж байна. Өөрөө Монгол болохоос оюун санаа, үнэт зүйлс, үйл хөдлөл, дадал зуршил, хэл, соёл нь харьсан хойч үеийг бэлдсээр байгаа нь харамсалтай. Үндэстнийг устгая гэвэл, хэлийг нь, соёлыг нь, үнэт зүйлсийг нь өөрчилж уусга гэсэн үг байдаг. Их мөрний урсгалд чулуу хүртэл элэгддэг гэсэн үг ч бий. АНУ-ын ерөнхийлөгч Дональд Трампын “Уучлаарай, дэлхийд ардчилал байхгүй. Та бүхэн байдаг, байдаг газраа өөрсдийн ёс уламжлалаараа амьдарцгаа”¹⁶ гэж хэлсэн үг ч бий. Иймд ондоошил, соёл, ёс уламжлалаа өөрсдөө хадгалж, тугаар тогтнолоо баталгаажуул эс бөгөөс бидний нэг хэсэг бол гэсэн дарангуйллын шинжтэй хүчирхэг гүрнүүдийн бодлого ч байхыг үгүйсгэхгүй.

Мэдээж дижиталчлалын эрин үед мэдээллийн төрөл бүрийн хэрэгслээс

¹⁵ https://www.nso.mn/mn/statistic/statcate/48171312/table-view/DT_NSO_2002_069V2., Бүх шатны боловсролын сургалтын байгууллагад суралцагчид. Үндэсний статистикийн хороо. УБ. 2024;

¹⁶ <https://www.bbc.com/news/articles/cjev2j70v19o>., <https://www.facebook.com/photo?fbid=2536025986738215&set=gm.9220967661334150&idortvany=2415683808529270>;

салж уламжлалт аж ахуйгаар үр хойчоо өсгөн хүмүүжүүлэе гэвэл өрөөсгөл ойлголт юм. Эсрэгээрээ мэдээллийн төрөл бүрийн хэрэгслийг ашиглаж, хүүхэд залуусынхаа нүдээр үзэж, гараар барьж чадахгүй байгаа бусад орны иргэдийн мэдэрч, харж үзэж, сонсохыг хүсдэг, үлгэр дуурайлал авдаг агуу түүх, ёс уламжлал, эх хэлний яруу тансаг илэрхийлэмж, дадал зуршил, амьдралын хэв маяг, байгаль эх дэлхийтэйгээ нэн ойр, хүйн холбоотой байх мэдрэмж, чадамж, эх оронч үзлийг олгох бүрэн боломж бий. Эх оронч Монгол хүнийг бага балчраас нь эхлээд төлөвшүүлэх ёстой гэсэн санаа юм. Тухайлбал: Бүх шатны боловсролын системд Монголын түүх, Монгол цэргийн түүх, ахуйн соёл, нүүдлийн иргэншлийг үечлэн программчилсан хичээл болгон оруулах. Үүнд: сургуулийн өмнөх боловсролын суралцагчдад Монгол ахуйн соёлыг тоглоом наадгайн аргыг ашиглан орчинд суралцуулах, ЕБС-ийн 1-12 дугаар ангид Монголын түүхийн хичээлийг заавал судлах хичээл болгон оруулах, Их дээд сургуулийн 1-2 дугаар курс, мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвд тухайн мэргэжлийн түүхийн хичээлийг заадаг болох.

Мөн гэр бүл судлалын хичээлийг онол, практикаар хослуулан (Монгол гэр бүлийн судлагдахуун дээр тулгуурлан) ЕБС-ийн ахлах ангид, их дээд сургуулийн 1-2 дугаар курс, мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвд заавал үзэх хичээл болгон судлуулах үндэслэлийг дараах тоон мэдээгээр баталгаажуулбал: Үндэсний статистикийн хорооны 2023 оны судалгаагаар гэр бүл салалтын тоо 4776 болж өмнөх оноос (2022 оны байдлаар 4553 байсан) 4.9 хувиар нэмэгдсэн¹⁷, 2019 онд гэр бүлийн хүчирхийллийн холбоотой 985 гэмт хэрэг бүртгэгдэж байсан бол 2020 онд 1138 болж өмнөх оноос 153 хэргээр буюу 15,5 хувиар өссөн байна. Гэр бүлийн хүрээнд хүний эрүүл мэндийн эсрэг болон хүчиндэх гэмт хэргүүд өссөн. Тухайлбал, 2020 онд гэр бүлийн хүчирхийллийн улмаас 18 хүн амиа алдаж, 953 хүн гэмтсэн нь өмнөх онтой харьцуулбал нас барсан хүн 2,3 дахин, гэмтсэн хүн 30,2 хувь, учирсан хохирол 54,7 хувиар өссөн¹⁸ байгаагаас харж болно.

Цахим үндэстэн гэсэн уриа лоозонгийн хүрээнд хиймэл оюуныг ашиглан Монгол төрт ёс уламжлалыг агуулсан, баатруудын дүр төрх, агсамж дуулга, эдлэл хэрэгслийг багтаасан, өвөрмөц хэллэг, хэлц үг, зүйр үгүүдээр баяжуулсан тоглоом, хүүхэлдэйн кино контент зохион бүтээж хэрэглээнд нэвтрүүлэх нь шийдлийн нэг хэлбэр гэж үзэж байна. Жишээ нь: PUBG / PLAYERUNKNOWN'S BATTLEGROUNDS/ шиг...

Дүгнэлт

Алтан амь, амьдралын хувь заяагаа золин байж туурга тусгаар улсаа тунхаглаж, үр хойчдоо өвлүүлэн үлдээсэн өвөг дээдсийн үйл хэргийг

¹⁷ https://www.nso.mn/mn/statistic/statcate/48171303/table-view/DT_NSO_0300_021V1;

¹⁸ <https://safefuture.mn/mongol-uls-dahi-huchirhiilliin-stat>;

үргэлжлүүлэх нь иргэн бүрийн чухал үүрэг. Монгол Улсын тусгаар тогтнолын баталгаа, үндэсний аюулгүй байдлын үнэт зүйл нь олон улсын гэрээгээр тогтоож, НҮБ-д бүртгэгдсэн хоёр бүс нутгийн уулзвар, хоёр их гүрний дунд, гурван том шашин, соёл иргэншлийн огтлолцол болдог нэн өвөрмөц геополитикийн орчинд орших нэг ч метрийн маргаангүй 8,252.658 км үргэлжлэх дархан хил нь эрхэмлэн нандигнах бат дархлаа болсон үнэт зүйл юм. Иймдээ ч Галдан бошгот “Миний нутгийн газар шорооноос бурхан гуйсан ч бүү өг” хэмээн тунхагласан болов уу.

Үндэсний сөрөн тэсвэрлэх, чадавхыг нэмэгдүүлэхийн тулд иргэн бүрд суурь хүмүүжил, төлөвшлийн хэлбэрэлтгүй дархлааг суулгах ёстой. Тэр нь эх орон ч үзэл, сэтгэлгээ, хандлага гэж ойлгож байна. Энэ ч үүднээс өнөөдөр хамгийн их алдагдаад байгаа хувь хүний зөв хүмүүжлийг өвөг дээдсийн үлдээсэн амьдралын туршлага дээр үндэслэн олгож хэвшүүлэх нь зүйтэй. Мэддэг нь түгээн дэлгэрүүлж, мэддэггүй нь суралцан хэрэгжүүлэх шаардлагатай байна. Ингэж гэмээн сая аюулыг ажрахгүй давах чадавхтай болно.

Эрх чөлөө, тусгаар тогтнолын баталгаа бол хүнээ хөгжүүлсэн нийгэм гэж ойлгодог. Монгол Улс үеийн үед хөгжин дэвжихийн бат илэрхийлэл нь өвөг дээдсийн минь мохошгүй зориг, мөхөшгүй үйл хэрэг, ганхашгүй бат итгэл үнэмшил, үнэт зүйл билээ. Тэнгэр заяат язгуур Монгол иргэд өнөөдөр эл үйл хэргийг үргэлжлүүлэх нь ариун журамт үүрэг гэдгийг ойлгон ухаарч өдөр тутмын амьдралдаа хэрэгжүүлэх ёстой.

Эшлэл авсан сурвалж, судалгааны бүтээл

1. 1992 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр. “Монгол Улсын Үндсэн хууль”.
2. Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолын хавсралт. “Монгол Улсын Үндэсний Аюулгүй Байдлын Үзэл Баримтлал”.
3. Улсын Их Хурлын 2011 оны намрын ээлжит чуулганы 12 дугаар сарын 28-ны өдөр (пүрэв гариг)-ийн хүндэтгэлийн чуулганы хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл.
4. Монгол Улсын Засгийн Газрын Тогтоол. 2019 оны 5 дугаар сарын 22-ны өдөр. Дугаар 200., УБ.хот. “Үндэсний хөтөлбөр батлах тухай”;
5. Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт. “Монгол Улсын Засгийн Газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”.
6. Монгол Улсын Ерөнхийлөгчийн Зарлиг. 2024 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр. Дугаар 166., УБ. “Монголын Түүх Судлалыг Дэмжих Тухай
7. Г.Цэрэнханд, Н.Маралмаа. “Монголын угсаатны зүйн судалгаа ба орчин үе”. УБ., 2020 он.
8. Я.Цэвэл. “Монгол хэлний товч тайлбар толь”. УБ., 2021 он.
9. Т.Эрдэнэхишиг “Хүннү, Хань улсын цэрэг, улс төрийн харилцаа”. УБ., 2009 он.
10. Олон Улс Судлал Vol. 46 | No 115 | 2023 <https://doi.org/10.5564/jis.v46i115.2685>.,

Академич, доктор Ц.Батбаяр. “Монгол Зөвлөлтийн харилцаа (1925-1928)”. УБ. 2023 он.

11. <https://www.nso.mn/mn/statistic/statcate/48171312/table-view/DTNSO2002069V2>.,Бүх шатны боловсролын сургалтын байгууллагад суралцагчид. Үндэсний статистикийн хороо. Уб. 2024 он.
12. <https://www.bbc.com/news/articles/cjev2j70v19o>.,<https://www.facebook.com/photo?fbid=2536025986738215&set=gm.9220967661334150&idortvanti=2415683808529270>;
13. <https://safefuture.mn/mongol-uls-dahi-huchirhiilliin-stat>;